



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 07 сарын 02 өдөр

Дугаар А/330

Арвайхээр

**Төслийн орон нутгийн зөвлөл байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 03/03 дугаар тогтоолоор батлагдсан “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.4.3.9 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Япон Улсын Гадаад хэргийн Яамны санхүүжилтээр Японы Хүүхдийг Ивээх сангаас хэрэгжүүлэх “Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь-2” төслийг орон нутагт удирдан чиглүүлэх үүрэг бүхий “Төслийн орон нутгийн зөвлөл”-ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга: С.Ундрах (Аймгийн Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга: Г.Батцэцэг (Японы Хүүхдийг ивээх сангийн салбарын ажилтан)

Гишүүд: Б.Сайнжаргал (аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Ж.Пүрэвсүрэн (аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын дарга)

Х.Гэрэлмаа (аймгийн Засаг даргын дэргэдэх Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын ахлах мэргэжилтэн, Хүүхдийн эрхийн улсын байцаагч)

Б.Норовсүрэн (аймгийн Засаг даргын дэргэдэх Насан туршийн боловсролын төвийн сургалтын менежер)

Ц.Цэндсүрэн (“Тэгш боломж” эцэг эхийн холбооны тэргүүн)

Б.Анхтуяа (“Тэгш боломж” эцэг эхийн холбооны тэргүүлэгч гишүүн)

Н.Гуамарал (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, явц үр дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд мэдээлж ажиллахыг Төслийн орон нутгийн зөвлөлийн дарга (С.Ундрах)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А. ИШДОРЖ

011100719